

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 дугаар сарын 13

Дугаар 85

Улаанбаатар хот

Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван тавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянзүрх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 31 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ... дугаар
сарын-ны өдрийн арван тавдугаар
хуралдааны дугаар тогтоолын
хавсралт

Баянзүрх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Нарийн бичгийн дарга:	Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
Гишүүд:	Засаг даргын орлогч Засаг даргын Тамгын газрын дарга Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Дүүргийн Ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Дүүргийн Цагдаагийн газрын дарга Зэвсэгт хүчний жанжин штабын нэгдүгээр орлогч Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Дүүргийн Газар зохион байгуулалтын I, II албаны дарга Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Баянзүрх дүүргийн замын цагдаагийн хэлтсийн дарга Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Баянзүрх дүүргийн хэлтсийн дарга “Гэр бүл, хүүхэд, залуучуудад эрх зүйн үйлчилгээ үзүүлэх Цагаан шонхор төв” Төрийн бус байгууллага